



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 5/47

Чингис хот

Д.Ганболдыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.3, 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Ганболдын хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан, мөн өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Саруултөгс	Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан ахлах мэргэжилтэн
	Т.Бямбадулам	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

3. Д.Ганболдтой эд хөрөнгийн тооцоог хийж дуусгахыг нярав, ажилласан хугацааны цалингийн болон бусад тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогчид тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

\* 231030187